



# МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

---

ДУГААР 15



# ШҮҮХИЙН АКАДЕМИ

## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

8,9  
CAP

2024.09.30 - Дугаар/15/



### ШҮҮГЧ-СУРГАГЧ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТ БОЛЛОО

Шүүхийн академи “Үр дүнтэй цахим сургалт зохион байгуулах нь” сэдэвт сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Шүүгч-сургагч багш нарт зориулсан энэ удаагийн сургалтад Улсын дээд шүүхийн сүлжээ, холбоо хариуцсан мэргэжилтэн Ж.Батнасан “Цахим сургалт зохион байгуулахад технологи ашиглах нь” сэдвийн хүрээнд сургалтын үзүүлэн, хэрэглэгдэхүүн, лекцийн тэмдэглэл бэлтгэхэд шаардлагатай зарим программын талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэсэн бол

Мэдээлэл технологи, хариуцсан инженер, график дизайнер Х.Ганболд, Э.Энгүүн нар “MS Power Point программ”-ыг ахисан түвшинд хэрхэн үр дүнтэй ашиглахыг практик жишээнд тулгуурлан тайлбарлах замаар тус тус хичээлийг удирдан явуулсан юм.

### ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧ-СУРГАГЧ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Шүүхийн академи, Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхим, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн “Just transition”-ийг хэрэгжүүлэхэд эрх зүйн зөвлөгөө өгөх шүүх эрх мэдлийн байгууллагуудын чадавхыг сайжруулах” төсөлтэй хамтран иргэний хэргийн шүүгч-сургагч багшид зориулсан сургалтыг 2024 оны 9 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Эхний 2 өдрийн сургалтыг ХБНГУ-ын Бавари мужийн Пассау хотын Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, ноён Рүдольф Хэлмхагэн эдийн болон эдийн бус баялгийн эрх зүй дэх шаардах эрх болон өв залгамжлалын эрх зүйн сэдвээр удирдан явуулсан бол 3 дахь өдрийн сургалтыг Улсын дээд шүүхийн шүүгч, Иргэний хэргийн танхимын Тэргүүн Г.Алтанчимэг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн шинэлэг асуудлын хүрээнд удирдан явууллаа.



### УРТЫН ЭЭЛЖИЙН АЖИЛТНЫ ИЛҮҮ ЦАГИЙН НЭМЭГДЭЛ ХӨЛСИЙГ ТООЦУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ



#### Дүн шинжилгээ №1

УРТЫН ЭЭЛЖИЙН АЖИЛТНЫ ИЛҮҮ ЦАГИЙН НЭМЭГДЭЛ ХӨЛСИЙГ ТООЦУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ

шийдвэрт хийсэн дүн шинжилгээг нийтэлж байна. Дүн шинжилгээг Шүүхийн академийн цахим хаягаас бүрэн эхээр нь унших боломжтой.

Монгол Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын хяналтын шатны хуралдаанаар 2024 оны эхний хагас жилд шийдвэрлэсэн онцлох хэргүүдийн тогтоолд Шүүхийн академиас дүн шинжилгээ хийж, цувралаар хүргэж эхэллээ. Энэ удаа УДШ-ийн 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 001/ХТ2024/00118 дугаартай “Уртын ээлжийн ажилтны илүү цагийн нэмэгдэл хөлсийг тооцуулах”-тай холбоотой шүүхийн

LIKE US ON FACEBOOK:

ШҮҮХИЙН АКАДЕМИ



www.jtrii.mn

LINKED IN:

JUDICIAL ACADEMY OF MONGOLIA



## СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХОРОО ШИНЭ ГИШҮҮДЭЭ ТОМИЛЖ, НЭГДСЭН БОДЛОГОО БАТАЛЛАА

Шүүхийн академийн Сургалтын хөтөлбөрийн хорооны ээлжит хуралдаан 2024 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулагдлаа. Хуралдааныг Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг нээж, "Шүүхийн сургалтын 2025-2027 оны нэгдсэн бодлого"-ын төслийг танилцуулан, хорооны гишүүдийн саналыг авч, нэгдсэн бодлогыг батлахад санал нэгдэв.

Энэ удаагийн хурлын онцлог нь Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Шүүхийн сахилгын хорооны төлөөлөл хуралд оролцсон явдал байв. Хуралд нийт 14 гишүүн оролцсоноос 3 нь цахимаар, 11 нь танхимаар оролцож, 93,3 хувийн хувийн ирцтэйгээр болж өнгөрлөө.



## ЗҮҮН БҮСИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН УУЛЗАЛТ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Шүүхийн академи Улсын дээд шүүхтэй хамтран шүүгчдийн заавал судлах, мэргэшүүлэх сургалтыг 2024 оны 9 дүгээр сарын 24-ний өдрөөс 9 дүгээр сарын 26-ны өдрүүдэд Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Говьсүмбэр аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах болон анхан шатны шүүх, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх, Багануур дүүргийн эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийг хамруулан Хэнтий аймагт зохион байгууллаа.

Сургалттай хамтатган Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа болон бусад шүүгчдийн бүрэлдэхүүн Шүүх байгуулах тухай хууль батлагдаж 2025 оноос эрүү, иргэний хэргийн шүүх нэгдэж буйтай холбоотойгоор эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шүүгчдэд Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого, Монгол Улсын шүүхийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт, шинэлэг зохицуулалтын талаар мэдээлэл хүргэн, шүүгч нарын санал бодлыг сонсон хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

## ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ №2 НИЙТЛЭГДЛЭЭ

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи нь Монгол Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын хяналтын шатны хуралдаанаар 2024 оны эхний хагас жилд шийдвэрлэсэн онцлох хэргүүдийн тогтоолд дүн шинжилгээ хийж, цувралаар хүргэж байгаа билээ. Энэ удаад зээлийн эрсдэлийн даатгалын гэрээний шаардах эрх Иргэний хуулийн 443.7-д заасны дагуу шилжих эсэх, энэ зохицуулалтыг 4971-тэй уялдуулан тайлбарлах асуудлыг хөндсөн Улсын дээд шүүхийн 2024 оны 06 сарын 04-ны өдрийн 001/ХТ2024/00126 дугаар тогтоолд хийсэн дүн шинжилгээг хүргэж байна. Дүн шинжилгээг Шүүхийн академийн цахим хаягаас бүрэн эхээр нь унших боломжтой.



### ДҮН ШИНЖИЛГЭЭ №2

"ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ШААРДАХ ЭРХ ИРГЭНИЙ ХУУЛИЙН 443.7-Д ЗААСНЫ ДАГУУ ШИЛЖИХ ЭСЭХ, ЭНЭ ЗОХИЦУУЛАЛТЫГ 4971-ТЭЙ УЯЛДУУЛАН ТАЙЛБАРЛАХ АСУУДАЛ"-ТАЙ ХОЛБООТОЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ